



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2006 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 01.

Улаан-Уул

**"Тэргүүний тариаланч" -д  
тодорхойлох тухай.**

6 -р багийн ногоочин Ц.Мөнхжаргал нь сүүлийн хэдэн жил газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж, 1 га - аас авах ургацын хэмжээг жил бүр нэмэгдүүлж, дагалдан ажиллуулах замаар 6 ажлын байр шинээр буй болгож 1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн ажил байдлын тодорхойлолтыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар авч хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. Аймгийн "Тэргүүний тариаланч" -д тодорхойлсон багийн ИНХ, сумын ЗДТГ-ын саналыг дэмжсүгэй.
2. Ц.Мөнхжаргалын ажил байдлын тодорхойлолт, бусад холбогдох материалыг аймгийн комисст уламлахыг сумын Засаг дарга С.Цэндэд даалгасугай.



ДАРГА  Н.БЯМБАСҮРЭН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  П.БЯМБАА

01 5105



Баянхонгор аймгийн Өлзийт сумын  
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн  
Тогтоол

2006 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 02

Улаан-Уул

Аймгийн "Тэргүүний тариаланч хадланч" -д  
тодорхойлох тухай.

Хадлангийн талбай, бэлчээрийг хашиж хамгаалан, шинээр суваг шуудуу татаж усжуулан, 1 га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлж, фермерийн аж ахуйн эхлэл тавьж байгаа ажлын арга туршлагыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар авч хэлэлцээд 5-р багийн ИНХ-ын хуралдааны материал, аймгийн Засаг даргын 412 дугаар захирамжийг үндэслэн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Ө.Лхамхүүг Аймгийн "Тэргүүний тариаланч, хадланч" -д тодорхойлсон багийн ИНХ, сумын ЗДТГ-ын саналыг дэмжсүгэй.

2. Ө.Лхамхүүгийн ажил байдлын тодорхойлолт, бусад холбогдох материалыг аймгийн комисст уламлахыг сумын Засаг дарга С.Цэндэд даалгасугай.



ДАРГА  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.БЯМБАСҮРЭН

П.БЯМБАА

01 5 107



3

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2006 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 03

Улаан-Уул

**Аймгийн " Сайн малчин " -д  
тодорхойлох тухай .**

18  
С.Баасан нь улс нийгэмд нийт 17 жил хөдөлмөрлөхдөө ХАА -н салбарын үндсэн үйлдвэрлэл болсон мал сүргийг 17 жил маллаж , байгаль цаг агаарын ямар ч нөхцөлд малаа тоо толгойн хувьд өсгөж байсны зэрэгцээ түүнээс ашиглах , ашиг шимийг нэмэгдүүлэх талаар ихээхэн анхаарч ямаагаа Өлзийт голын Улаан , ухнаар , хонио Байдраг үүлдрийн хуцаар хээлтүүлж чанарыг сайжруулснаар 30.6 % нутгийн шилмэл омгийн түвшинд хүрсэн болно .

Залаа нийлж тухай  
салаа

189  
2005 оны жилийн эцсийн тоогоор бодод шилжүүлснээр 165 малтай , 3 айл өрхийг малжуулжээ. *Эрхэм төлөвт сүүний 3 жилд 336 172,5 төгрөгийг татварт оруулсан байна*  
2-р багийн ИНХ - ын тэмдэглэл , Сумын Засаг даргын Тамгын газрын санал бусад холбогдох материалыг хэлэлцээд ИТХ - ын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

малны

*аар батлагдсан Аймагийн санал*  
1. 2005 оны 412 дугаар захирамжинд заагдсан шалгуурыг хангасан байдлыг харгалзан Аймгийн " Сайн малчин " -аар тодорхойлсон багийн ИНХ, сумын ЗДТГ-ын саналыг дэмжсүгэй .

2. С.Баасангийн ажил байдлын тодорхойлолт , бусад холбогдох материалыг аймгийн комисст уламлахыг сумын Засаг дарга С.Цэндэд даалгасугай.



ДАРГА *[Signature]* Н.БЯМБАСҮРЭН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *[Signature]* П.БЯМБАА

01 5 109





4

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2006 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 09

Улаан-Уул

**Эмийн Эргэлтийн Сангийн  
Удирдах болон Хяналтын зөвлөл  
байгуулах тухай**

Эрүүл мэндийн тогтвортой үйлчилгээ төслийн хүрээнд сумын Э.Э.С ажиллуулах зорилгоор ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ ;

Нэг . Сумын Э.Э.С – ийн Удирдах зөвлөлийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга ; С.Цэнд / Сумын Засаг дарга /

Гишүүд ; Ц.Оюун / Хүн эмнэлгийн эрхлэгч /

В.Түвшинсайхан / Эмийн сангийн эрхлэгч /

Д.Жавзан / Төсвийн ня-бо /

М.Пүрэвсүрэн / Эмнэлгийн НЭМ ажилтан /

Д.Нарантуяа / ТББ- төлөөлөгч /

Ё. Түмэндэмбэрэл / Иргэдийн төлөөлөгч /

Хоёр. Хяналтын Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай .

Дарга ; Н.Бямбасүрэн / ИТХ – ын Тэргүүлэгчдийн дарга /

Гишүүдэд ; Ц.Алтанцэцэг / Эх баригч Бага эмч /

Ц.Амгалан / Иргэдийн төлөөлөгч /

Гурав. Орон нутгийн хэмжээнд эмийн хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгийн эх үүсвэрийг байнга өсгөж үйл ажиллагааг хэвийн хангаж ажиллахыг Удирдах зөвлөлд даалгасугай .

Дөрөв. Сумын Эмийн эргэлтийн сангийн болон Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллахыг Хяналтын зөвлөлд үүрэг болгосугай .



ДАРГА *[Signature]* И.БЯМБАСҮРЭН

*4/8-ийн дарга*

*[Signature]* Т.В.Бидаа

*ИТХ-и  
2013. 04.02-ийн  
35р тогтоолоор  
агуушгүй  
бэлч*





Баянхонгор аймгийн Өлзийт сумын  
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн  
Тогтоол

2006 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 05

Улаан-Уул

Төлөвлөгөө батлах тухай

Сумын ИТХ-аас 2006 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцээд ИТХ-н Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Сумын ИТХ-н 2006 оны ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Хоёр: Ажлын төлөвлөгөөг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд идэвхи санаачлагатай ажиллахыг тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

Гурав: Төлөвлөгөөний биелэлт үр дүнг тооцон 12-р сард тэргүүлэгчдийн хуралд оруулахыг Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга П.Бямбаад даалгасугай



ДАРГА  Н.БЯМБАСҮРЭН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  П.БЯМБАА



6

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2006 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 06

Улаан-Уул

**Төлөвлөгөө батлах тухай .**

Сумын 2006 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцээд Газрын тухай хуулийн 18-н 7-г үндэслэн ИТХ-н Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Сумын 2006 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Хоёр. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг газрын даамал Ц.Мөнхзүлд, уг төлөвлөгөөг эрхлэх ажлынхаа хүрээний үйл ажиллагаанд баримталж ажиллахыг сумын засаг дарга С.Цэндэд үүрэг болгосугай.

Гурав. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавиж ажиллахыг ИТХ-н тэргүүлэгч Г.Болдоод үүрэг болгосугай



ДАРГА  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.БЯМБАСҮРЭН

П.БЯМБАА

01 5-13

**ӨЛЗИЙТ СУМЫН 2006 ОНЫ ГАЗАР ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Төлөвлөгөөний зорилго:** Газрын тухай багц хууль, тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх, газар эзэмшигч, өмчлөгчийн эрхийг баталгаажуулахад оршино.

Дэвшүүлсэн зорилт	Хэргэжүүлэх арга зам	Хугацаа	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт	Биелэлт
1	2.	3	4	5	6
Нэг Газрын харилцааг боловсронгуй болгох талаар	1. Сумын 2006 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хийж ИТХ-аар батлуулах	1-р улиралд	Газрын даамал БОХУ-ын байцаагч	Төлөвлөгөөтэйгээр газрыг олгох	
	2. Байгууллага аж ахуйн нэгжийн эзэмшил газарт тооллого хийж эзэмшил газрыг баталгаажуулах шинэ гэрээ гэрчилгээгээр одоо эзэмшиж байгаа газрыг хэмжээгээр нь олгох	2-р улирал	Засаг дарга Газрын даамал	Байгууллага аж ахуйн нэгжийн эзэмшил газар баталгаажсан байна.	
	3. Ердийн ашигт малтмал ашигласаны төлбөрийг 2006 онд ашигт малтмал ашигласан тохиолдолд бүрэн авах	Улирал бүр	Газрын даамал БОХУ-ын байцаагч	Төлбөр тооцох нөхөн сэргээх асуудлаар эрх зүйн үндэс бүрдэнэ.	
Хоёр Газрын тухай хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлж иргэн, ААН-д газрыг эзэмшүүлэх ажил зохион байгуулах	1. Иргэн аж ахуйн нэгж байгууллагад газар тариалангийн зориулалтаар газар олгох	2-р улиралд	Газрын даамал	Тариалангийн газрын харилцааг сайжруулах	
	2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урьд нь олгосон газрыг зориулалтын дагуу ашигласан төлбөр тооцоо хийсэн эсэхийг харгалзан гэрээний дагуу шинэчлэн олгоно. Дээрхи шаардлагыг биелүүлээгүй газар эзэмшигчээс гэрээг цуцалж газрыг буцаан авна.	2-р улирал	Газрын даамал	Газрын хуулийн дагуу хийгдсэн байх	
	3. 2006 онд сумын хэмжээнд өмчлүүлэх боломжтой нийт-6.2га газрыг Монгол улсын иргэнд хүсэлтийнх нь дагуу өмчлүүлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	Засаг дарга Газрын даамал	Иргэд өөрийн өмчийн газартай болох нөхцөл бүрдэнэ.	



Гурав. Газрын мэдээллийн сан шилжилт хөдөлгөөн	1. Газрын мэдээллийн санг өргөжүүлж газрын шилжилт хөдөлгөөнийг цаг тухай бүрд нь бүртгэх.	Жилдээ	Газрын даамал	Иргэдэд үнэн зөв мэдээллээр үйлчилэх.	
Дөрөв. Газрыг хамгаалалтанд авах, нөхөн сэргээх сайжруулах	1. Шаардлагатай зарим газрыг сумын тусгай хэрэгцээнд авах болон түүх дурсгалын газруудыг сумын тусгай хамгаалалтанд авах 2. Ашигт малтмал олборлох, авто зам тавих болон бусад зориулалтаар ухааж эвдсэн газрыг сэргээн сайжруулах ажлыг зохион байгуулах. /Төв зам дагуух болон Бумбат зэрэг зарим газрууд /	Жилдээ	Газрын даамал Соёлын байгууллага	Дээрхи газрын тоо хэмжээ урьд оноос нэмэгдсэн байх	
Тав. ХАА-н ашиглалт хамгаалалтыг сайжруулах	1. Бэлчээрийн даацыг судлаж малын тоо толгойг тохируулах үндсэн дээр бэлчээрийн <del>төрөл</del> <i>арьсгал</i> хянаж хянагдах. 2. Малчдыг оторт явуулах, тухайн жилийн бэлчээрийн гарц иргэд малчдын саналыг харгалзан өвөлжөө хаваржааны газрыг хамгаалах 1. 3Г-ын 2002 оны 241-р тогтоолын дагуу газар эзэмшигч бүрт шалгалт хийж дунг аймагт МХА-д хүргүүлэх. 2. Газрын төлбөрийг орон нутгийн төсөвт бүрэн оруулах, урьд онд төлөгдөөгүй төлбөрийг нөхөн оруулах. 3. Газрын маргааныг зохих журмын дагуу хүлээн авч шийдвэрлэх.	Жилдээ	Газрын даамал БОХУ-ын байцаагч Сумын засаг дарга Газрын даамал Багийн засаг дарга нар	Газрын механик элэгдэл эвдрэлийг багасгах, нөхөн сэргээх сайжруулах Бэлчээрийн газрын зохистой харьцааг өндөрдөн ажиллах. Өвөлжөө, Хаваржааны бэлчээрийг хамгаалах	..
Зургаа. Хяналт шалгалт хийх маргааныг шийдвэрлэх	1. 3Г-ын 2002 оны 241-р тогтоолын дагуу газар эзэмшигч бүрт шалгалт хийж дунг аймагт МХА-д хүргүүлэх. 2. Газрын төлбөрийг орон нутгийн төсөвт бүрэн оруулах, урьд онд төлөгдөөгүй төлбөрийг нөхөн оруулах. 3. Газрын маргааныг зохих журмын дагуу хүлээн авч шийдвэрлэх.	Жилдээ	Газрын даамал БОХУ-ын бацаагч	Шалгалтын дүн мэдээг тухай бүрд нь хүргүүлсэнээр Газрын төлбөрийн орлогыг бүрэн хэмжээгээр төвлөрүүлэх Маргаан зөрчил гарсан тухай бүр шийдвэрлэнэ.	
Долоо. Бусад асуудал	1. Газрын тухай болон газар өмчлөх хуулийн талаар иргэд, аж ахуйн, байгууллагад сургалт явуулж сурталчилгаа хийх.	1.2-р улиралд	Газрын даамал БОХУ-ын бацаагч	Газрын талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлнэ.	

Сүүнэ

СУМЫН ЗАГААГ ДАРГА, ГАЗРЫН ДААМАЛ, БОХУ-ЫН БАЙЦААГЧ

8



9

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2006 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 07

Улаан-Уул

Хөшөө тохижуулах, комисс байгуулах тухай

Хүслийг биелүүлэгч ээжийн цагаан хөшөөг тохижуулах ажлын талаар хэлэлцээд ИТ-ийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Хүслийг биелүүлэгч ээжийн цагаан хөшөөг тохижуулах комиссыг дорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: ИТХТ-н дарга Н.Бямбасүрэн

Нарийн бичгийн дарга: Сумын засаг дарга С.Цэнд

Гишүүдэд: Г.Болдоо

С.Ганбат

Ө.Дамчий

Д.Мягмарсүрэн

Д.Эрдэнэчимэг

Ц.Эрдэнэбаатар

Б.Өлзийбаатар.

Хоёр. Хөшөө тохижуулах ажлыг 2006 оны 07-р сарын 01-ны дотор гийж дуусгах ажлын төлөвлөгөө гарган ажиллахыг комисст үүрэг болгосугай.

Гурав. Хөшөөг тохижуулах ажилд хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг засаг дарга С.Цэндэд үүрэг болгосугай.

Дөрөв. Хөшөөг тохижуулах ажилд "Буяны өглөг" өргөхийг нийт ард иргэд сүсэгтэн олонд уриалсугай.



ДАРГА *Н.Бямбасүрэн* Н.БЯМБАСҮРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *П.Бямбаа* П.БЯМБАА

togtool2006

18 6001